

**“МОН-НАБ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

2023 оны 04 дүгээр
сарын 06-ны өдөр

Дугаар 01


Улаанбаатар хот

*Тооллогын комиссийн дарга, гишүүдийг
сонгох тухай:*

**“МОННАБ” ХКомпаний Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас
ТОГТООХ нь:**

- Компанийн 2022 оны үйл ажиллагааны , санхүүгийн байдалд ТУЗ-н өгсөн дүгнэлт ;
- ТУЗ-н ажлын тайланг хэлэлцэж батлах;
- Компанийн үйл ажиллагааны цаашдын зорилтыг хэлэлцэж батлах;
асуудлаар санал хураалтыг тоолох тооллогын комиссийн
даргаар Б.Гүенбаатар, гишүүнээр Г.Баярбаатар нарыг олонхийн
саналаар сонгон ажиллуулсугай.

ХУРЛЫН ДАРГА



Р.ЗОРИГТ

**“МОН-НАБ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2023 оны 04 дүгээр
сарын 06-ны өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот


Тайлан батлах тухай

“Компаний 2022 оны үйл ажиллагааны үр дүн, цаашдын зорилтын тухай” ТУЗ-ийн дарга Р.Зоригтын Хувьцаа эзэмшигчдийн хуралд тавьсан тайланг хэлэлцээд, Монгол Улсын “Компанийн тухай хууль”-ийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалтыг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Компанийн 2022 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг баталсугай.

2. Компаний үйл ажиллагааны талаар 2023 онд дэвшүүлсэн зорилтыг бүрэн хангах, Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал дээр хувьцаа эзэмшигч нараас гаргасан санал, шүүмжлэлийг үйл ажиллагаандаа тусгаж, хэрэгжүүлэн ажиллахыг компанийн Гүйцэтгэх захирал /Ш.Оюун-Эрдэнэ/-д үүрэг болгосугай.

ТУЗ-н ДАРГА



Р.ЗОРИГТ

**“МОН-НАБ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТООЛЛОГЫН
КОМИССИЙН ТОГТООЛ**

2023 оны 04 дүгээр
сарын 06-ны өдөр

Дугаар 03

Улаанбаатар хот

**Хувьцаа эзэмшигчдийн саналыг
тоолсон дүнгийн тухай**

Хувьцаа эзэмшигчдийн саналын хуудсаар ирүүлсэн саналыг тоолж үзэхэд нийт тараагдсан саналын хуудас 5 ширхэг, санал аваад буцаж ирсэн 5 ширхэг хуудсанд 100171 ширхэг хувьцааны санал ирсэн байна. Энэ нь нийт хувьцааны 81,6 % болж үүнээс хүчинтэй 5 ширхэг саналын хуудас, хүчингүй 0 ширхэг саналын хуудас байна.

Эдгээр саналыг хэлэлцсэн асуудал бүрээр тодорхойлбол:


Хуралд тус компанийн хувьцаа эзэмшигч:

1. Компанийн 2022 оны үйл ажиллагааны , санхүүгийн байдалд ТУЗ-н өгсөн дүгнэлтийг зөвшөөрсөн 100171 ширхэг буюу 100 %, зөвшөөрөөгүй байхгүй .
2. ТУЗ-н ажлын тайланг хэлэлцэж батлахыг зөвшөөрсөн 100171 ширхэг буюу 100 %, зөвшөөрөөгүй байхгүй .
3. Компанийн үйл ажиллагааны цаашдын зорилтыг хэлэлцэж батлахыг зөвшөөрсөн 100171 ширхэг буюу 100 %, зөвшөөрөөгүй байхгүй.

Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцсэн асуудал тус бүрээр хувьцаа эзэмшигчдийн саналын хуудсыг тоолоход :

- Т. Бадамжунай / 62400 ширхэг хувьцаа эзэмшигч/
 - Р.Зоригт / 37497 ширхэг хувьцаа эзэмшигч/
 - З.Бүдсүрэн / 137 ширхэг хувьцаа эзэмшигч /
 - Л.Пүрэв / 137 ширхэг хувьцаа эзэмшигч /
- нар тус тус хүрэлцэн ирж, ирц 81.6 хувьтай байв.
тус тус тоологдож хэлэлцсэн асуудлыг 100 % санал нэгтэй баталлаа.

Тооллогын комиссын дарга
комиссын гишүүн



Г.Гүенбаатар
Г.Баярбаатар

Б.Гүенбаатар
Г.Баярбаатар